

ДОЛООН ӨВГӨН ОДНЫ ШҮТЛЭГИЙГ БИЧГИЙН ЭХ СУРВАЛЖИД ТУЛГУУРЛАН ШИНЖЛЭХ НЬ

*С.Янжинсүрэн (Ph.D)
Ц.Эрдэнэцэцэг (Магистрант)
Философи, шашин судлалын тэнхим
ШУС. МУИС*

Түлхүүр үг: Шанага долоо, Долоон өвгөн од, Долоон бурхан од, Дохиур долоон од, Долоон өвгөн одны судар, Тэнгэрийн оргилго, Тэнгэрийн хас, Тэнгэрийн шил, Тэнгэрийн эрхи, Тэнгэрийн бэрээ, Нэхэх арга, Жиргэлзэх гэрэл.

Товч утга: Монголчууд нар, сар, алтан гадас од, хүн таван од, үүрийн цолмон буюу үдшийн гялаан болон долоон бурхан зэрэг оддыг өөрсдийн амьдралдаа нөлөөтэй гэж үзэж шүтэж ирсэн байна. Иймээс Монголчуудын эртний шүтлэгийн хэлбэрт од, гараг эрхсийн шүтлэг чухал байр суурь эзэлдэг. Гэвч хожим энэ шүтлэг Монголчуудын хүлээн авсан бурхны шашны сав, шим ертөнцийн тогтоц бүтэц, одон зурхайн онолоор баяжигдан, нийт Монгол туургатны дунд од эрхсийн шүтлэгийн нэгэн сонин содон хэлбэр болж тогтжээ. Энэ дунд бидний нэрлэдгээр “Долоон бурхан” одны шүтлэг чухал байрыг эзлэх бөгөөд энэ тухай бичмэл/текстэн/ сурвалж ч нэлээд буй юм. Онцгойлон Долоон бурхан одны зан үйлийн нэгэн судар Монгол Ганжуурын “Элдэв зүйлийн аймаг” буюу 92 дугаар ботид \378 доод-383 дээд талд\ хадгалагдаж үлджээ.

Бид тус өгүүллээр Монгол Ганжуур дахь “Долоон өвгөн нэрт одны судар”(эх бичиг)-т судалгаа хийж, улмаар судрын агуулгаар дамжуулан энэ бүлэг одонд монголчууд хэрхэн, ямар арга, зан үйлээр шүтлэг одуулж ирснийг тодруулж, түүнд судлаачдын зүгээс үнэлэлт, дүгнэлт өгч, санал бодлоо хуваалцахыг зорилоо.

* * * * *

Шашны эх зохиол - судар номуудад эх бичгийн судалгаа хийж, улмаар уг судрын зохиогдсон цаг хугацаа, зохиогч, бичигдсэн хэл бичиг, уламжлагдан хадгалагдаж ирсэн байдал, хувилбар - түүний адил болон ялгаатай тал, тархалт, эх сурвалжийн агуулга, үзэл санааг эдүүгээчлэн нээн илрүүлж, судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах нь шашин судлал, шашны онол, түүх, эх бичиг судлалын чухал зорилт юм. Энэ нь тухайн судар номд герменевтик тайлбар хийх бэлтгэл болдог билээ. Гэвч эртний ном зохиол нь тухайн цагийнхаа утга зохиолын хэл найруулгаар бичигдсэн байдаг тул аливаа эх зохиол дээр ажиллана гэдэг тийм

ч амар, хялбар ажил биш юм. Иймээс түүнийг тааж унших, таамгаар ойлгох бус, үнэн зөвөөр тайлж унших нь нэн чухал болно.

Бидний судалгааны эх зохиол болох “Долоон өвгөн нэрт одны судар”-ыг анх Бурхан багш айлдсан гэж Монгол Ганжуурт тэмдэглэжээ¹. Улмаар Энэтхэгт үүссэн бурхны шашин умардаас умардад дэлгэрхийг дагалдан Бурхан багшийн айлдсан энэ судар ч энэтхэгээс гарч хятадаар дамжин дорно дахины бусад ард түмнүүдэд тухайлбал, Монгол, Уйгур, Төвөдөд уламжлагдан дэлгэрчээ. Ингэхдээ тэдгээр улс, үндэстнүүдийн хэл, бичигт нь хөрвөж, сүсэгтэн ардуудад ухаарч ойлгогдсоноор, тухайн газар орны ардуудын язгуур шашин шүтлэгтэй сүлэлдэж, улмаар төв азийн буддын соёлт үндэстнүүдийн дунд “Долоон бурхан” одны тусгайлсан шүтлэгийн нэгэн хэлбэр болж тогтсон нь ажиглагдана. Иймд “Долоон өвгөн нэрт одны судар”-ууд нь нэр, агуулга, орчуулгын талаар бага зэрэг зөрөөтэй байдал ажиглагдана.

Хятад хэлт Долоон өвгөн одны судрыг монголчууд уламжлан авч эх хэлнээ орчуулан хэрэглэсэн бөгөөд “Долоон өвгөн нэрт одны судар”-ын төгсгөлийн үгнээс үзэхэд уйгурууд монголчуудтай нэгэн үе өөрийн эх хэлнээ хөрвүүлсэн тухай дурджээ. Гэвч чухам ямар хэлнээс орчуусныг бичээгүй байна. Магадгүй хятад хэлт эх сурвалжаас авсан байж болно.

Харин Төвөдүүд Монгол хэлт эх сурвалжаас авч өөрийн хэлнээ орчуулан шашин шүтлэгтээ хэрэглэх болсон нь бидний судалгааны эх сурвалжуудад тухайлбал, Монгол Ганжуурын 92 дугаар ботийн 378б-383а тал, “Долоон өвгөн нэрт одны судар”, Төвөд хэлт Сундуй \gcungs bsdus\ буюу Тогтоолын хураангуй судрын 228а-232а талууд дахь “Долоон өвгөн одны судар”, академич Ц.Дамдинсүрэнгийн эмхтгэсэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой” дахь монгол бичмэл Сундуйгаас авсан “Долоон өвгөн хэмээх одны судар”, буриадаас олдсон гэдэг “Долоон өвгөний тахилга” гэх шүлэг болон УННС-ийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа “Оддын урилга хийгээд Долоон өвгөн нэрт одны судар” зэрэг судруудад тодорхой бичигджээ.

Долоон өвгөн од нь одон орон судлалд тус тусын нэртэй байдагчлан үндэстнүүд өөр өөрийн хэлээр тухайлбал, санскрит, хятад, монгол, төвөд хэлээр нэр өгч тогтоосон байна².

Судруудын агуулгаас үзвэл нь монголчууд долоон өвгөн одонд буян заяа гуйх, урт нас хүсэх, нүгэл хилэнцээ нимгэлэх, өвчин хуучаа арилгах, үрийн заяа гуйх, үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхныг даатгах тэргүүтэн, мөн мал сүргээ өсгөх, тоо толгойг нь даатгах, эд баялагаа арвижуулах, ан авын олз ашиг гуйх зэрэг олон зорилгоор шүтэж, ингэхдээ тусгай зан үйлүүдийг үйлддэг байжээ.

Долоон өвгөн одны шүтлэгийн зан үйлүүд нь дээрх судруудаар дамжин илэрч байгаагийн зэрэгцээ ард олны өдөр тутмын шашин шүтлэгийн эрэлт, хэрэгцээгээр илэрч байгаа нь ч байна.

¹ Монгол Ганжуур. 92 дугаар боть, “Долоон өвгөн нэрт одны судар”, 382б талд.

² Мөн тэнд.

Долоон өвгөн одны шүтлэгт холбогдох зан үйлд **долоон өвгөн одыг тахих, долоон өвгөн одонд зул өргөх болон долоон өвгөн одноо мал сэтэрлэх** зэрэг зан үйлүүд байгаа нь тодорхой байна. Ингэхдээ чухам юуг гуйж байгаагаасаа шалтгаалан зан үйлүүд дэх үйлдлүүд, хэрэглэх зүйлс, үйлдлийн дараалал нь өөр өөр байна.

Долоон өвгөн одны шүтлэгийн зан үйлүүд өвөрмөц онцлогтой бөгөөд тухайлбал, Долоон өвгөн одонд зул өргөх зан үйлээс үзвэл нь од тус бүрт 12 жилийг ялган харьяалуулж тухай тухайн жилд төрсөн хүмүүн төрсөн жилд оноосон одыг шүтдэг. Ингэхдээ одод бүрт өргөлийн идээ нь өөр өөр байх бөгөөд долоон од тус бүрт бурхны шашны долоон бурхныг \Намсэг-Snam seg, Жүгдэр-Gthug tor, Тамжаджав-Thams cad Skyabs, Хорвоонжиг-'Akhör ba 'ajig, Сэртүв-Gser thub, Одсүрэн-'Od srung, Шагжтүв- Sha'akya thub pa\ байршуулж од тус бүрт тарни оноон уншиж шүтдэг ажээ.

Долоон бурхан одыг XXI зуунд ч монголчууд шүтсэн хэвээр байна. Ингэхдээ түүнд ихэнхдээ сүү өргөдөг хэлбэр тогтжээ. Хэрэг дээрээ тус одны сударт сүү өргөх биш од бүрт өөр өөр будаа өргөдөг болох нь тодорхой байна. Шашин шүтлэгүүд ард түмнүүдийн соёлын хөрсөнд таацан хөгждөг уламжлалыг долоон өвгөн одны шүтлэг ч тойроогүй. Учир нь энэ шүтлэг монголчуудын эрхлэх аж ахуй, соёлтой нь уусаж будаа өргөхийн оронд хамгийн өргөн хэрэглэдэг, хүндэт идээ “цагаан идээ”-гээ өргөдөг заншил тогтсон байна.

Ингэж шашин шүтлэгийн хэлбэрүүд ард түмнүүдийн ахуй амьдрал, соёлын хөрсөнд нь таацан хөгждөг бөгөөд судар ном, үлгэр домгууд нь ч тухай тухайн ард түмний соёлын амьдралтай нягт сүлэлдэн уламжлагддаг болохыг Долоон өвгөн одонд холбогдох эх сурвалжууд нотолж байгаа болно.

Монголчууд долоон өвгөн одны тухай судар ном, залбирал, тахилгын шүлгүүд, домог үлгэр зэргийг зохион хэрэглэж, хадгалснаас гадна тэдгээр оддыг тахин тайж³ ирсэн байна. Долоон өвгөн нэрт одны шүтлэг нь өөрийн дүрэм, зан үйлтэй бөгөөд түүнийг тахидаг нутаг нутгийн зан үйл байдаг.

Долоон өвгөн одны шүтлэгийн зан үйлд хамаарах долоон өвгөн одыг тахих зан үйл, долоон өвгөн одонд зул өргөх зан үйл, долоон өвгөн одноо мал сэтэрлэх зан үйл гэсэн 3 зүйлийн зан үйл одоогоор бидэнд тодорхой болоод байна. Монгол туургатны уудам нутагт өөр бусад зан үйл байхыг ч бас үгүйсгэх аргагүй.

Долоон өвгөн од нь үзэгдэх байдлын хувьд шанага хэлбэртэй харагддаг учраас **“Шанага долоон од”** хэмээн нэрлэдэг. Энэхүү шанага хэлбэртэй долоон одыг шанаганы амсраас иш рүү хандуулан тоолдог.

³ Тахилга нь бурхан номын шүтээний биет сурвалж юм. Тө: Gsol mchod, “Бурхад, ядам, чойжингууд хийгээд газрын эздэд зориулсан тахил тайлгын ерөнхий нэр болой”, Эмх. Д.Дэмбэрэлдорж, Э.Равдан, “Бурхны шашны нэрийн тайлбар толь”, МУИС, Гадаад хэл соёлын сургууль, Нэр судлалын төв. УБ., 2009, 79 дэх талд.



Монголчууд эдгээр одыг тахихдаа идээ, будааны дээж, сүү, тараг тэргүүтэн өргөж заншжээ. Гэтэл бидний олж цуглуулсан долоон бурхны шүтлэгийн зан үйлд холбогдох судруудад долоон бурханд цагаан идээ өргөдөг тухай тэмдэглээгүй байх бөгөөд монголчууд ийнхүү сүү

цагаан идээ өргөдөг болсон нь өөрсдийн аж амьдрал, эрхлэх аж ахуйтайгаа нийцүүлж өөриймшүүлжээ гэж дүгнэж байна.

Судруудад тэмдэглэснээс үзвэл: Долоон бурхан одны долоон од нь тус бүртээ нэртэй, харгалзах жилтэй, тус тусын тахилгын идээтэй байна. Харгалзах жилд төрсөн хүн тухайн одыг шүтэх учиртай ажээ. Үүнд:

1. Долоон өвгөн одны нэгдүгээрх нь **Дамлан** *ʈam lang* нэрт од юм. Дамлан нэрт одонд хулгана жил харгалзах бөгөөд тахих идээ нь Монгол амуу юм. Долоон өвгөн нэрт одны судрын **379а талд** Дамлан нэрт одыг хэрхэн шүтэх тухай: “... Долоон өвгөн нэрт одны анх тэргүүнд Дамлан нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буй. Хулгана жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь монгол амуу буй. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болжюу” хэмээсэн байна.
2. Долоон өвгөн одны хоёрдугаарх нь **Гүнмин** *kun min* нэрт од юм. Гүнмин нэрт одонд үхэр, гахай 2 жил харгалзах бөгөөд тахих идээ нь Хоного амуу юм. Энэ тухай сударт “Хоёрдугаар Гүн Мин нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буюу. Үхэр жилт хийгээд гахай жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Түүнийг тахихуй идээ хүнс нь хоного амуу буй. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болжюу” хэмээжээ.
3. Долоон өвгөн одны гуравдугаарх нь **Лүсүн** *lu sun* нэрт од юм. Лүсүн нэрт одонд бар, нохой 2 жил харгалзах бөгөөд тахих идээ нь тутарга байна. Энэ тухай сударт: “Гутгаар **Лү Сүн** нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буюу. Бар жилт бөгөөд нохой жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь тутрага буюу. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болжюу” хэмээжээ.
4. Долоон өвгөн одны дөрөвдүгээрх нь **Үнхү** *ʼun phu* нэрт од юм. Үнхү нэрт одонд туулай, тахиа 2 жил харгалзах бөгөөд тахих идээ нь буудай юм. Энэ тухай сударт дараахь байдалтай бичжээ: “Дөтгөөр **Үнхү** нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буй. Туулай жилт бөгөөд тахиа жилт хүн хүн энэ

одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь буудай буюу. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болюу” хэмээжээ

5. Долоон өвгөн одны тавдугаарх нь **Лимцум** *lim tshim* нэрт од юм. Лимцим нэрт одонд луу, бич жил харгалзах бөгөөд тахиж идээ нь олсны үр юм. Энэ тухай сударт “Тавдугаар **Лим Цим** нэрт одон буй. Түүний (х.3796) сахиан чакра нь энэ буюу. Луу жилт хийгээд мичин жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь олсны үр буюу. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болюу” гэжээ.
6. Долоон өвгөн одны зургадугаарх нь **Вүгү** *ibu gu* нэрт од юм. Вүгү нэрт одонд хонь хийгээд могой жил харгалзах бөгөөд тахиж идээ нь хар буурцаг байна. Энэ тухай: “Зургадугаар **Вүгү** нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буюу. Хонин жилт хийгээд могой жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь хар буурцаг буюу. Ад тотгор нь болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болюу” гэжээ.
7. Долоон өвгөн одны долдугаарх нь **Вүгүн** *bu gun* нэрт од юм. Вүгүн нэрт одонд зөвхөн морь жил харгалзах бөгөөд тахиж идээ нь ногоон буурцаг юм. Энэ тухай эх сурвалжид дараахь байдлаар тэмдэглэжээ: “Долдугаар **Вү Гүн** нэрт одон буй. Түүний сахиан чакра нь энэ буюу. Морин жилт хүн энэ одонд харьяат төрмүй. Тахихуй идээ хүнс нь ногоон буурцаг буюу. Ад тотгор болбоос энэ ном бичгийг тахиж сахиан чакра нь биедээ зүүгдэхүй. Ад тотгор нь устаж ахуй их баясгалант болюу” хэмээжээ.

Долоон өвгөн оддын латин, монгол, төвөд нэрс, тэдгээрт харгалзах бурхан, жил, тахилгын идээ зэргийг судруудад тэмдэглэснийг дээрхээс нэгтгэн хүснэгтээр үзүүлбэл дараахь байдалтай байна:

Дугаар	Латин нэр	Монгол нэр	Төвөд нэр	Харгалзах бурхан	Жил	Тахилгын идээ
I од	Dubhe	Тэнгэрийн оргилго	Дамлан Tam Lang	Намсэг	Хулгана	Монгол амуу
II од	Merak	Тэнгэрийн хас	Гүнмин Kun min	Жүгдэр	Үхэр, Гахай	Хоного амуу
III од	Phad	Тэнгэрийн шил	Лүсүн Lu sun	Тамжаджав	Бар, Нохой	Тутрага
IV од	Megrez	Тэнгэрийн эрх	Үнхү 'Un phu	Хорваанжиг	Туулай, Тахиа	Буудай
V од	Aliot	Тэнгэрийн бэрээ	Лимцим	Сэртүв	Луу, Бич	Олсны

			Lim tshim			үр
YI од	Mizar (Modico)	Нэхэх арга	Бүгү Lbu gu	Одсүрэн	Хонь, Могой	Хар буурцаг
YII од	Alkaid	Жиргэлзэх гэрэл	Бүгүн Bu gun	Шагжтүв	Морь	Ногоон буурцаг

Долоон өвгөн од тус бүртээ тарнитай бөгөөд дараах байдалтай байна.

Дугаар	Латин нэр	Монгол нэр	Төвөд нэр	Тарни
I од	Dubhe	Тэнгэрийн оргилго	Дамлан Tam Lang	Нама Саманда бүдда нан. Ум а ми ха яаа, яа суухаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om a mi dha ya'a ya swa'a ha'a.
II од	Merak	Тэнгэрийн хас	Гүнмин Kun min	Нама Саманда бүдда нан. Ум цинда хум ни суухаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om tshindha h'um ni swa'a ha'a.
III од	Phad	Тэнгэрийн шил	Лүсүн Lu sun	Нама Саманда бүдда нан. Ум ни ми ди ни ла га ха на вар рү дү сү суухаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om ni mi di ni la ka ha na bar mru du su swa'a ha'a.
IY од	Megrez	Тэнгэрийн эрх	Үнхү 'Un phu	Нама Саманда бүдда нан. Ум вэ ха раа хаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om we ha sra'a ha'a.
Y од	Aliot	Тэнгэрийн бэрээ	Лимцим Lim tshim	Нама Саманда бүдда нан. Ум ба ра ди за ра ма ра на суухаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om pa ra ti tsa ra ma ra na swa'a ha'a.
YI од	Mizar (Modico)	Нэхэх арга	Бүгү Lbu gu	Нама Саманда бүдда нан. Ум ва ха ра са ма еэ суухаа. Na ma sa manta bud dha'a na'an. Om srba ngha ra sa ma ye swa'a ha'a

YII од	Alkaid	Жиргэлзэх гэрэл	Вүгүн Bu gun	Нама Саманда бүдда нан. Ум са ба да ба ра ми на за суухаа.
				Na ma sa manta bud dha'a na'an. Om sa pa ta pa ra mi na tsa swa'a ha'a.

Долоон бурхан одонд зул барих буюу зул өргөх зан үйл гэж байна. Тэдгээрт зөвхөн сарын тогтсон нэг өдөрт зул өргөнө. Үүнд:

1. Хаврын тэргүүн сарын шинийн долоонд,
 2. Хаврын дунд сарын шинийн дөрвөнд,
 3. Хаврын эцэс сарын шинийн хоёронд.
 4. Зуны тэргүүн сарын хорин долоонд,
 5. Зуны дунд сарын шинийн таванд
 6. Зуны эцэс сарын хорин гурванд,
 7. Намрын тэргүүн сарын хоринд,
 8. Намрын дунд сарын арван долоонд,
 9. Намрын эцэс сарын хоринд,
 10. Өвлийн тэргүүн сарын арван нэгэнд,
 11. Өвлийн дунд сарын арван таванд,
 12. Өвлийн эцэс сарын шинийн найманд тус тус нэг удаа буюу жилд
- 12 удаа дээрх тогтсон өдрүүдэд зул өргөж залбирна. Судруудад тухайлсан од тус бүрт зул өргөх тухай заасангүй, харин нийтэд нь зул өргөдөг болох нь тодорхой байгаа юм.

Монголчууд Долоон өвгөн нэрт одны судрыг зохиож, тус оддыг тахиx зан үйлийг бүтээн, мөн тахиxдаа уншдаг тахилгын болон залбирлын шүлгүүдийг зохиож иржээ. Шүлэгт долоон өвгөн нэрт одонд юунд, ямар учраас тахил өргөж байгааг шүлэглэжээ⁴. Тус шүлэгт “ийм жилт тийм омогт өчүүхэн хүн”-тахил өргөгчөөс гаралтай ба эрүүл энх өсөн хүмүүжиж, эрийн зэрэгт хүргэх, түмэн цэргээ төвлөн засаж, мянган цэргээ төвлөн засагч болгохыг хүсэж, долоон өвгөн нэрт одонд даатган тахил өргөж байгааг илэрхийлжээ. Үүнээс гадна, “Дээр ерэн өсөн тэнгэрийн дээд хан хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр”, “Хамгийн дээд хан заяагч тэнгэр”-ийн өлзий хутаг орштугай гэж, “Албин чөтгөр арилж, үхэл зовлон үгүй болтугай гэж ариун тахил тахинам” гэж шүлэглэжээ. Эндээс үзвэл долоон бурхан одыг төрөл бүрийн зорилгоор шүтдэг байсан байна.

Долоон өвгөн нэрт одны тахилгын сударт “харахуйг зурхай болготугай! Харвахуй эрхийг онон заяатугай” гэх ба “улаан үнэгийг буруу бөгтрөг гэж, унах морийг зөвөөр хөтөлтүгэй” хэмээн ан агнах болон ангийн олз омогоо долоон өвгөн одонд даатгаж забирч даатгалын шүлэг, даатгалын үг хэлдэг байсныг харуулж байна.

⁴ Мөн тэнд.

Түүнчлэн монголчууд мал сүргийнхээ үржил шим, бүрэн бүтэн байдлыг долоон өвгөн одонд даатган залбирдаг уламжлалтай байна. Ялангуяа мал сүрэг хээр хонох тохиолдолд түүнд тусгайлан өргөл тахилаа өргөж, хангайн амьтан, араатнаас мал сүргээ аварч хамгаалахыг даатган гуйдаг уламжлал дэлгэрч байжээ. Монголын аль ч нутагт үдэш орой сүү саалийнхаа дээжийг долоон бурханд өргөж, мал сүргийнхээ тоо толгойг даатгадаг заншилтай байжээ. Долоон өвгөн одыг “нэгэн гагц гүүг мянган цагаан адуу болгогч”, “нэгэн гагц хонийг мянган цагаан хонь болгогч” хэмээн дээд шүтээнээ болгон үзэж хүндлэн тахидаг байжээ.

Тахилгын шүлэгт буддын шашны агуулга бага. Харин “хүй ихт ерэн есөн тэнгэр, хөвчин ихт далан долоон этүгэн эх”, “ой болдог омогт, нарсан модон найлзуурт, навч цэцэг гишүүт, могой толгойтой, морин улаат, халзан цагаан хонин тахилгат, хамгийн дээд хан заяагч тэнгэр” гэх мэт бөө мөргөлийн дээд шүтээн болсон тэнгэр, газар дурдагдах бөгөөд “есөн зул, хүж, жимс, цай, архи, халзан цагаан хонь, есөн сацал” гэх зэрэг бөө мөргөлийн буюу эртний монголчуудын сайн сайхныг бэлгэддэг тоонууд гардаг гэж С.Дулам үзжээ. Эдгээр бүхэн нь долоон өвгөн нэрт одны шүтлэг нь бөө мөргөлийн үед байсан бөгөөд Бурхны шашин монголд нэвтрэх үед түүнтэй сүлэлдэн бурхны шашны агуулгаар баяжсан байна гэж үзэж байгаа болно.

Монголчуудын долоон өвгөн одыг тахиж тайлах зан үйл нь нутаг, нутагт өөр өөр байна. Тухайлбал, Ордосын монголчууд долоон өвгөн одыг тахиыхыг долоон бурхад тахина гэж хэлдэг. Тэд ихэнхидээ цагаан сарын шинийн долоонд тахидаг. Энэ өдрийг ордосын монголчууд жилийн хар өдөр, хүний хишиг өдөр хэмээн бусад айл өрхөд шинийн золголт хийхээр очихгүй, мөн ч тус өдөр гэрээс гарч аян замд явахгүй. Ан гөрөө хийдэг хүмүүс харин энэ өдөр жилийн анхны мөр гаргах гэж зээр, туулай агнадаг.⁵

Долоон бурхан тахидаг ордос айл тахилга хийх өдрийн оройг битүүний оройтой адил бэлгэдэн өнгөрөөдөг ба идээ цагаа бэлдэж даллага авч⁶ “Долоон бурхадын тахилгын өчиг”-ийг, тухайлбал:

“Хүй ихт ерэн есөн тэнгэр,

Хөвчин ихт далан долоон этүгэн эхээс үүдсэн

Ерэн түмэн одны дундаас

Долоон өвгөн нэрт одноо

Есөн зул, хүж, жимс, цай, архи, халзан цагаан хонь,

Есөн сацал бэлдэж ариун тахил тахин мөргөнөм”⁷ гэхчлэн зуугаад мөртэй шүлэглэсэн өчгийг уншиж Долон бурханаас буян хишиг гуйж зан үйл үйлддэг байна.

Өвөр Монголын зүүн орны монголчуудын дотор ч долоон бурхныг шүтэх зан үйл ихээхэн дэлгэрсэн ч голдуу цагаан сарын шинийн долоонд тус тахилгыг үйлддэг. Орой одон мичид огторгуйд түгсэн үед хүрээ хорооны дунд ширээ засаж, дээр нь хүж, зул шатаан, идээ ундааны зүйлсийг өрж, долоон өвгөн одны зүг хандан сөхрөн залбирч мөргөдөг. Бас тэрчлэн үр хүүхэдгүй айл долоон өвгөн

⁵ Г.Намжил, “Монгол буддын шашны утга зохиолын судлал”, Хөх хот., 2013, 179

⁶ Мөн тэнд, 180 дахь талд.

⁷ Мөн тэнд.

одноос үр хүүхэд гуйх зан үйл болох **“Долоон хүүхдийн найр”**-ыг хийдэг. Найрт долоо буюу долоогоос дээш тооны хүүхэд оролцуулдаг ба насанд хүрэгсэдийг оролцуулдаггүй журамтай тухай болон газар газрын монголчуудын долоон өвгөн одны шүтлэгтэй холбогдох зан үйл элдэв янз байж, үүний дотор өвөр монголын сөнөдийн долоон бурхан одонд малаа сэтэрлэх заншил нь эрт үеэс уламжлалтай байсан талаар Г.Намжил нэгэн сэдэвт бүтээлдээ тодорхой тэмдэглэсэн байна.⁸ Тэнгэр, од зэрэгт сэтэрлэсэн малыг нядлаж хүнсэнд хэрэглэх нь бүү хэл зодож хараахыг цээрлэж, хутга мэсийн зүйл хүргэж болохгүй. Сэтэртэй морь, тэмээг унаж эдлэхийг цээрлэдэг.

Ленинградын дорно дахины судлалын хүрээлэнгийн номын санд **“Долоон өвгөнөө малыг сэтэрлэх”** хэмээх судар буйг эрдэмтэн Н.Поппе 1932 онд бичсэн “Монгол бөөгийн бичмэл номын тухай” өгүүлэлдээ дурджээ.

Ойрадчуудад бас малаа долоон өвгөн одонд даатган сэтэрлэх зан үйл дэлгэрсэн байдаг. Эдгээрээс үзвэл, долоон өвгөн нэрт одонд мал сэтэрлэх заншил нь монгол угсаатнуудад нэлээд түгээмэл байсан ажээ.

Монголжины монголчууд алсад байгаа төрөл садныхаа амар төвшин байдлыг даатгаж, шөнө бүр хойд зүг хандан “дохиур долоон одонд” мөргөдөг заншилтай байсан гэнэ. Бас жил бүр шинэлэхээс өмнө сүм хийдэд очоод ламд гэрийн хүмүүсийнхээ нас жилийг нь хэлж өгөөд хэн хэн нь ямар ямар од тахихыг мэдэж авна.⁹

Бидний мэдэж буйгаар Юань улсын үед хятад хэлнээс орчуулсан “Долоон өвгөн нэрт одны судар”-т ямар жилтэй хүн долоон өвгөн нэрт одны алинд нь харьяат төрөх ба ямар идээгээр харьяат одоо тахихыг нэг нэгээр тэмдэглэсэн байдаг. Монголчуудын ямар нас, жилтэй хүн ямар одыг тахих тухай сүм хийдийн ламаас асуудаг зан, зуршил нь дээрхээс уламжлан залгамжилсан байж мэдэх юм.

Дээрх мэтчилэн долоон өвгөн нэрт одны тахилгын зан үйл ялгамжаатай байжээ. Эртний монголчууд тэдгээр зан үйлийг гүйцэтгэж, долоон өвгөн нэрт одонд сүсэг бишрэлээ илэрхийлвэл урт насалж, удаан жаргах ба мал сүрэг өсөн үржиж, аж амьдралаа дээшлүүлэх хүслээ шивнэн даатгадаг байна.

Бас, “Сундуй судар” дотор байгаа **“Долоон өвгөн одны судар”**-ын төгсгөлийн үгэнд: *“...Бас язгуурын хөвгүүн, язгуурын охин, хамаг төрөлхтөн бүгдээр долоон өвгөн одыг мэдэж, минийхийг үйлдэх болой (өөрийнхөө жилийн сахигч одыг мэдэх). Үргэлжид амьдрахын тулд нэгэн насанд хэдий чинээ саад тотгор, хэрэггүй наадам, хамаг мууг үзэх болбоос долоон өвгөн хэмээх одны эзнийг (х.232а) мэдэж энэ номд өргөл хүндлэлийг сэтгэлдээ үүсгэж тахиснаар хорлол хийгээд хамаг саад тотгорыг тасалж, хэн ч хорлож үл чадна хэмээн номлосон болой”*¹⁰ гэжээ. Эндээс үзвэл сэтгэл санаагаа тогтоон цэгцлэх зорилгоор ч долоон өвгөн одыг шүтдэг байсан байна.

“...Түүнээс залуу Манзушир тэргүүтэн дөрвүүл орчлонд цуглаад энэ номын зарлигийг өргөн хүндэлж, билиг таван үе гишүүнээр мөргөөд одсон болой. На мо

⁸ Мөн тэнд, 183 дахь талд.

⁹ Мөн тэнд. Өвөр Монголын өвөр 49 хошууны Түмэдийн чуулганд багтаж байсан ба одоогийн Хятадын Ляонин мужид багтаж буй.

¹⁰ Монгол Ганжуур, 92 дугаар боть, “Долоон өвгөн нэрт одны судар”, 232а талд.

ра дан зи ра за дэ маха за зи ра ава бра а ги суухаа. Тэнгэрийн тэнгэр бурхан бээр зарлигласан долоон өвгөн хэмээх одны нас уртатгагч хэмээгдэх номын судрын бөлөг болой” гэжээ.

Монголчууд нэлээд эрт дээр үеэс долоон өвгөн нэрт одыг бусад од мичидийн хамтаар сүсэглэн биширч байжээ. Гэхдээ тэдгээр долоон одыг бусад од мичидээс ялган салгаж тогтмол цаг орон ба ёслол дүрэмтэй тахиж эхэлсэн нь арван дөрөвдүгээр зууны үед монголын зарим язгууртан ноёд тэргүүлэн “Долоон өвгөн нэрт одны судар”-ыг уншин тахиж, долоон өвгөн нэрт одыг шүтэн биширч байсан ба тус судрыг дурдатган сануулж монгол хэлнээ орчуулан олны хүртээл болгожээ.

Юань улсын үед “**Долоон өвгөн нэрт одны судар**”-ыг тахих шашны тахилгын зан үйлийг зарим монгол ноёд машид хүндэтгэн тахиж байсан бололтой. Тэд тус судрыг “Дулдуйдах сэтгэлээр дурдаад хэн тахиваас тус ач нь түүнд болмуй” хэмээн бат итгэж байснаар барахгүй, тус судрыг “ариун бишрэл сэтгэлээр үргэлж уншиж тахисан”-аас Тогоонтөмөр хан хөвгүүн урт насалж, “хаан оронд суувай” хэмээн, долоон өвгөн нэрт одны шүтлэгийг хаан эзэд бие махбодын лагшин тунгалаг, эрүүл энх, урт насалж удаан жаргах ба хаан ор сууж, хамаг улсаа захирах зэрэг төр улсын томоохон үйл явдалтай холбон үзэж байжээ.

Иймээс тухайн үеийн эрх мэдэл бүхий буддын шашинд сүжигтэй язгууртнууд өгүүлэн буй судрыг монгол хэлэнд орчуулж ард олонд түгээхийг зарлиглаж байжээ. Өрөгбөх зэрэг ноёдын дэмжлэгээр энэ судрыг монгол хэлэнд орчуулж бас уйгур, төвөд хэлэнд түүнээс орчуулж цааш түгээжээ.

Юань улсын Төвтөмөр хааны үед орчуулагдсан “**Долоон өвгөн нэрт одны судар**”-ыг монгол хэлэнд орчуулсан хүн төгсгөлийн шүлэгт өгүүлэхдээ тус судрыг “*Монголын хэлээр орчуулбай би.....төгсгөн мянган тоотон тамгалуулбай*” гэсэн нь бий юм. Юань улсын үе дэх “**Долоон өвгөн нэрт одны судар**”-ыг хоёр мянган хувь хэвлэн ард олонд түгээжээ. Ном судар хэвлэн тархаах нөхцөл бололцоо муу үед уул судрыг олноо түгээсэн явдал нь монголчуудаар тэрхүү судрыг шүтэж, тахиулах зорилготой байсан бөгөөд энэ нь “**олон монгол иргэн бишрэлээр тахитугай**” гэснээс тодорхой харагдаж байна.

Тухайн үед “**Долоон өвгөн нэрт одны судар**”-ыг эх хэлэндээ орчуулж тамгалуулан түгээсэн явдлыг машид хүндэтгэж

“Энэ сайн буяны ач үрийн хүчээр

Эзэн хаан, хатан алтан ургаар

Эрсч мөнх жаргаад буянууд дэлгэрч

Эцэст бурхны хутгийг олох болтугай.

Эл улсын хямралдах дайсан амарлиад

Энд тотгоргүй энх амууж

Элдэв хий хур цагт орж зуд турхан үгүй болоод

Эл хэлэлсээр сэтгэсээр хэрэг нь бүттүгэй”¹¹ гэж ерөөсөн байна. Энэ мэтчилэн “**Долоон өвгөн нэрт одны судар**”-ыг бишрэн тахихыг хүндэтгэн

¹¹ Эмх. Ц.Дамдинсүрэн, “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой”, УБ., 1959, 132 дахь талд.

сайшааж тус судрыг төдий олон хувь тамгалуулан түгээж байсан нь долоон өвгөн одны шүтлэг, тахилгын зан үйлийг олныг хамарсан өргөн хүрээнд явуулах зорилготой байжээ. Тийм учраас долоон өвгөн одны шүтлэг, түүнд холбогдох судар, зан үйл өнөөг хүртэл хадгалагдаж үлдсэн байх.

НОМ ЗҮЙ

А. Судар

1. Монгол Ганжуурын 92 дугаар боть, “Долоон өвгөн нэрт одны судар”, 378 доод-383 дээд тал.
2. Төвөд Сундуй судар дотор буй “Долоон өвгөн одны судар”, 228 дээд-232 дээд тал.

3. Б. Судалгааны бүтээл

4. Ц.Баатарцогт. “Нийгмийн шинжлэх ухааны судалгааны аргууд”, УБ., 2012.
5. Б.Батцэцэг, П.Оюунгэрэл, “Домог үлгэр”, Монсудар хэвлэлийн газар, УБ., 2015.
6. М.Гаадамба, Д.Цэрэнсодном, “Монгол ардын аман зохиолын дээж бичиг”, (Их, дээд сургуулийн оюутнуудад зориулав) ШУА-ийн хэвлэл УБ., 1967.
7. Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой”. УБ., 1959.
8. Банзарын Дорж, “Монголчуудын харын шүтлэг ба бөө мөргөл”, 1932.
9. С.Дулам, “Монгол домог зүйн дүр”, УБ., 1989.
10. Г.Намжил, “Монгол буддын шашны утга зохиолын судлал”, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо, Хөх хот., 2013.
11. Бертольд Лауфер, “Монгол зохиолын түүхэн найруулал”, 1907.
12. Николас Поппе, “Монгол бөөгийн бичмэл номын тухай”, 1932.
13. Д.Цэрэнсодном, “Монгол ардын үлгэр”, ШУА.ХЗХ, УБ., 1982.
14. Д.Цэрэнсодном, “Монгол ардын домог үлгэр”, ШУА.ХЗХ, УБ., 1989.

ABSTRACT

The star and planets are played main role in faith objects of Mongolians ancient religious faith, such as the sun, the moon, the pole star, the five star, the evening star and the big dipper.

Some stars we call such as “Doloon burkhan odnii zan uiliin sudar “ (The Ritual scripture for the Big dippers) the Mongol Ganjur (dKa 'gyur) remained volume 92th (378 lower-383th above).

In this article, we tried to explore the text for the Big dipper in scripture in Mongolian Ganjur and aimed to analyze the rituals belongs to Mongolians “Big dipper faith”.